

*Ю.Бадамханд -ХСИС-ийн Хууль сахиулахын
удирдлагын академийн Цагдаагийн удирдлага,
стратегийн профессорын багийн дэд профессор,
хууль зүйн доктор (Ph.D), цагдаагийн хурандаа*

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХИРГААНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ИРГЭДИЙН
ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГХАНГАХАСУУДАЛ**

Товч утга: Хүний эрх¹, эрх чөлөөг хангах асуудал хууль сахиулах салбарын бүх байгууллагад хамааралтай, тэд бүгд өөр өөрийн онцлогтой хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлдэг. Энэ өгүүлэлд цагдаагийн байгууллагаас үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль хэрэглэх асуудлын талаар судалж, тодорхой санал дэвшүүлэхийг зорьсон болно.

Түлхүүр үгс: хүний эрх, эрх чөлөө, цагдаагийн байгууллага, захиргааны үйл ажиллагаа, хууль хэрэглэх, удирдлага, олон улсын баримт бичиг.

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсч, Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрч, улмаар "Иргэний болон улс төрийн эрхийн тухай", "Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай" олон улсын Пакт, бусад хүний эрхийн талаархи НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, Үндсэн хуулиндаа хүн бүр эрх тэгш байхыг тунхаглаж, үндсэний хууль тогтоомждоо нийцүүлэх, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, эрх зүй, бүтэц, зохион байгуулалтын олон арга хэмжээ авч ирсэн хэдий ч янз бүрийн нөхцөл шалтгааны улмаас хүний эрх зөрчигдөх, иргэн, албан тушаалтан үүргээ умартах явдал оршсоор байна.

Хууль сахиулах салбарын, тэр дундаа цагдаагийн байгууллагаас үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангах асуудал чухал бөгөөд хүндрэл бэрхшээлийг дагуулдаг ба хууль хэрхэн хэрэглэж байгаагаас хүний эрх, эрх чөлөөг хангах тогтолцоон дахь субъект бүрийн үйл ажиллагаа хир оновчтой, боловсронгуй байх асуудал шууд хамаарна гэж хэлж болно.

Хүний эрх, эрх чөлөөг тодорхойлсон хэм хэмжээний гол баримт бичгүүд, холбогдох стандартууд нь ихэнхдээ нийтлэг шинжтэй байдаг. Харин

¹ “Хүний эрх” гэдэг нь хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой. /Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын нэгдүгээр зүйл.

тэдгээр баримт бичиг, стандартуудыг хэрхэн баримталж байгаа вэ? гэдэг асуудал дэлхийн улс орон бүрт харилцан адилгүй, заримд нь бүр шаардлагын хэмжээнээс доогуур буюу буурсан үзүүлэлттэй байгаа нь олон шалтгаантай хэдий ч, зарим талаар уг баримт бичгүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардал хөрөнгө, зөрчилдөөн хийдэл, удирдлага зохион байгуулалттай холбоотой гэж зарим судлаачид¹ үзэж байна. Хууль эрх зүйн аливаа асуудлын шийдвэрлэлтийн үнэн зөв байх нь 1-рт: хуулийн шаардлага, 2-рт: түүний практик хэрэгжилтээр шууд илэрнэ.

Дээрх асуудлууд нь тодорхой нөхцөл байдлаар нөхцөлдөж, хүний эрх, эрх чөлөөг хангах стандартуудыг тогтоосон хэм хэмжээний актуудад тусгалаа олж, тэдгээрт захиргааны үйл ажиллагаа, тэр дундаа цагдаагийн² байгууллагын энэ талын үйл ажиллагааны журам, зөвлөмжийг³ тусгасан байдаг. Бодит нөхцөл байдалд яг ингэнэ, тэгнэ гэж нарийн стандартчилж, журамлах нь мэдээж боломжгүй, тиймээс ч зарим үед хэрхэх асуудал тодорхой бус, ойлгомжгүйгээс хүний эрх, эрх чөлөөг хангах ажлын чанар, үр дүн буурах нь бий.

Нөгөөтэйгүүр төр засгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудын чанаргүй ажлын гүйцэтгэлтэй шууд холбоотой. Энд тодорхой албан тушаалтан субъектив шалтгааны улмаас хүний эрх, эрх чөлөөг бүрэн хангахын тулд эрх зүй (хууль хэрэглэх), зохион байгуулалтын бүх талын арга

¹ И.А.Адмиралова. Правоприменительный процесс в сфере административной деятельности полиции по обеспечению прав и свобод граждан. /<http://lawlibrary.ru/article2343396.html>; А.А.Булавкин. Основные направления деятельности полиции по обеспечению прав и свобод гражданина в современном обществе.

² Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаа нь тодорхой үр дүнд чиглэсэн, тогтоосон дэг журмын хүрээнд хэрэгждэг, засагласан, эрх олгосон, зохион байгуулалттай хууль хэрэглэх үйл ажиллагаа юм. Цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны гол онилог нь өөрийн агуулгаараа захиргааны эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлдэг, хэлбэрийн хувьд захиргааны процессын үйл ажиллагаа болно. /.....

³ Орчин үеийн төрийн механизмд цагдаагийн байгууллага нь онцгой байр суурийг эзэлдэг. Тэрээр хууль сахиулах байгууллагууд дотроо хамгийн олон төрлийн үүргийг хэрэгжүүлж, нийтийн хэв журам, олон нийтийн аюулгүй байдал, иргэн, хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн ба бусад эрх, эрх чөлөөг ханган хамгаалах чиглэлээр шууд (хяналт-шалгалтын бүрэн эрхийг хэрэгжүүлдэг) ба шууд бус (лиценз-зөвшөөрөл олгох, бүртгэх) захиргааны үүргийг гүйцэтгэдэг./.....

⁴ Монгол Улсад одоогоор 500 гаруй хууль, 800 гаруй хэм хэмжээний акт хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас цагдаагийн байгууллагын хэмжээнд 100 гаруй хууль, 200-д хэм хэмжээний актууд мөрдөгдөж байна. Цагдаагийн байгууллагын дотоод үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн актыг системчлэх ажил 2008 оноос эхэлж, өнөөгийн байдлаар хууль тогтоомжид үндэслэсэн 256 журам батлагдан хэрэгжиж байна. Цаашид ЦБҮАЖ-д хууль тогтоомжид заасан цагдаагийн алба хаагчийн гүйцэтгэх үүргийг нарийвчлан зааж өгсөн нь хүний эрхийн стандартад нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох шаардлага байна. /Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам хүний эрхийн зарчимд нийцсэн байдал судалгааны тайлан. ХСИС, Нээлттэй нийгэм хүрээлэн. УБ. 2018.

хэрэгсэл, боломжоо ашиглахгүй байгаа явдлын тухай өгүүлж байна. Энэ нь нэг талаас хууль тогтоомжид оруулж буй олон удаагийн нэмэлт өөрчлөлт, тэдгээрийн ойлгомжгүй байдал (нэг их олон эрх үүрэгтэй, гэтэл хэрэгжүүлэх механизм тодорхой бус. эсхүл өөрийн үзэмжээр аль нэгийг хэрэглэж болох гм.). хийдэл зэрэг нь хүний эрх, эрх чөлөөг хангах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна. Тухайлбал: ЭБШХ-ийн 42 дугаар бүлэг¹, насанд хүрээгүй хүмүүсийн хэрэгт байцаан шийтгэх ажиллагаа явуулах журамд* ² зааснаар насанд хүрээгүй хүнийг байцаах цаг хязгаартай, ө.х. мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь завсарлагагүйгээр 2-оос илүү цагаар байцаалт, мэдүүлэг авч болохгүй. Байцаалтын нийт хугацаа өдөрт 4 цагаас илүүгүй байх ба эдгээр заалтыг мөрдөхгүй байх нь байцаалтын явцад ядарч, илүү ачаалал авснаас насанд хүрээгүй этгээд хууль бус мэдүүлэгт гарын үсэг зурах магадлалыг дагуулах эрсдэлтэй.

Энэ асуудлыг нөгөө талаас нь авч үзвэл зарим зөрчилдөөн байна. Насанд хүрээгүй хүнийг байцаах цагийн хязгаарлалт нь зөвхөн насанд хүрээгүй буюу 16-аас дээш насны сэжигтэн, яллагдагчийн тухайд яригдах бөгөөд ийм насны гэрч, хохирогчийн талаар үг, өгүүлбэр уг хуулинд тусгагдаагүй байна. Мөн эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй үедээ гэмт хэрэг үйлдэн шалгагдаж байгаа, гэмт хэргийн гэрч, хохирогч болсон бага насны хүүхдээс мэдүүлэг (байцаалт) авах тохиолдолд хэрхэх талаар хуульчлагдаагүй, олон улсын гэрээ, конвенцид тусгагдсан 3-6 насны хүүхдийн нэг удаагийн байцаалт 20 минутаас, 7-13 насны хүүхдийнх 1 цагаас хэтрэхгүй байх гэсэн зөвлөмжийн талаар тэр болгон яригдахгүй байна. Энэ фактыг даруйхан засан өөрчилөх шаардлагатай хуулийн цоорхой гэж үзэж болох ба уг журмыг байцаан шийтгэх ажиллагаанд оролцогч бүх насанд хүрээгүй хүмүүст нэг адил үйлчилэхээр хуульчилах шаардлага буй. Түүнчилэн дээрх хуулинд³ насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг байцаахад сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчийг оролцуулах /байлцуулах асуудал нарийвчлан зохицуулагдаагүй юм⁴.

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль. 42 дугаар бүлэг “Насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн хэрэгт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах тусгай журам”. //Төрийн мэдээлэл. УБ. 2002. № 1.

² Мөн хууль. 370 дугаар зүйл. Насанд хүрээгүй сэжигтэн, яллагдагчийг байцаах журам. //Төрийн мэдээлэл. УБ. 2002. № 1.

Мөн хууль. 371 дүгээр зүйл. Насанд хүрээгүй этгээдийн байцаахад сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах. //Төрийн мэдээлэл. УБ. 2002. № 1.

Ю.Бадамханд. Насанд хүрээгүй хүмүүсээс байцаалт авахад тулгамдаж буй асуудал. /ХСИС. ЦС-ийн Мөрдөх албаны тэнхим. ЭШБХ. 2017.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлагдсан “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”-д...хууль хэрэгжүүлэх албан тушаалтан гэдэгт цагдаагийн бүрэн эрх эдэлдэг, ялангуяа бусдыг баривчлах, хорьж саатуулах эрх бүхий томилдог болон сонгогддог бүх албан тушаалтнууд хамаарна...” хэмээн тодорхойлж, “тэдгээр нь үүргээ биелүүлэхдээ бүх хүмүүсийн нэр төрийг хүндэтгэж тэдний хүний эрх, эрх ашгийг хамгаалан дэмжинэ” гэж тусгасан байдаг. Энэ баримт бичиг болон НҮБ-ын Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц²-д эрүү шүүлтийг³ хориглох талаар заасан байдгийг бас анхаарч, аливаа этгээд (гэмт хэрэгт сэжиглэгдсэн шалгагдаж байгаа, гэрч хохирогч, эрүүгийн хэргийн бусад оролцогч)-ээс мэдээлэл, мэдүүлэг авах, байцаан шийтгэх ажиллагааг явуулахдаа тэдгээрийн эрх, ашиг сонирхол нь зөрчигдөхөөс сэргийлэн ажиллах нь бидний эрхэм зорилго билээ.

Аливаа асуудлыг хуульчлан тогтооход эрх зүйн эх сурвалжийг⁴ оновчтой ашиглах, боловсруулах процесс ажиллагаанд ардчилсан зарчмаар хандах, практикт хэрэгжихүйц байхад анхаарах нь мөн чухал ба хууль хэрэглэх процесс ажиллагаагүйгээр бид төр засгийн ажил, тэр дундаа цагдаагийн байгууллагын хүний эрх, эрх чөлөөг хангах салбарын үйл ажиллагааг төсөөлөх боломжгүй юм.

Хууль хэрэглэх нь хүний эрхийг хэрэгжүүлэх нэг хэлбэр, хууль баримтлах, биелүүлэх, ашиглах бусад хэлбэрээс өөрийн гэсэн онцлогоор

¹ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор батлагдсан.

² 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол улс 2000 оны 11 дүгээр сарын 2-нд нэгдэж орсон. //“Төрийн мэдээлэл. I боть. УБ.,2004, 109 дэх тал.

³ Конвенцийн заалт ёсоор бол “эрүүдэн шүүх гэж хэн нэгэн хүн буюу гуравдахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сэрдэгдсэн хэрэгт шийтгэх, айлан сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчлах зорилгоор төрийн албан тушаалтан, албан үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ” гэжээ. Харах: Иргэний бопон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт.

⁴ Эрх зүйн эх сурвалжийн хамгийн гол шинж бол эрх зүйн хэм хэмжээ агуулсан байхыг шаарддаг. Эрх зүйн хэм хэмжээнүүд нь төрийн бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг журамлаж, улам боловсронгуй болгож байдаг.

Доктор (Ph.D) Б.Чимэд төрийн удирдлагын явцад үүссэн нийгмийн харилцааг зохицуулагч эрх зүйн хэм хэмжээний илэрхийлэгдэх хууль зүйн хэлбэрийг захир, ааны эрх зүйн эх сурвалж гэсэн бол түүний үзэл баримтлалд үндэслэн доктор П.Одгэрэл (Ph.D): “захиргааны эрх зүйн эх сурвалж” гэдэг нь “захиргааны үйл ажиллагааны эрх зүйн үндэслэл болж буй тэрхүү эрх зүйн хэм хэмжээнүүдийн нийлбэр цогц юм. Мөн захиргааны эрх зүйн хэм хэмжээг агуулж буй бүхий л эрх зүйн актууд нийлж захиргааны эрх зүйн эх сурвалжийн тогтолцоог бүрдүүлнэ”. /П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги. УБ. 2016. 60 дахь тал.

ялгаатай байна. Энэхүү ялгаатай талыг авч үзэхийн өмнө эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх бусад хэлбэрийн талаар авч үзье.

Хууль биелүүлэх - захиргааны эрх зүйн хэм хэмжээ - нь тухайн субъект (иргэн, албан тушаалтан)-ын идэвхгүй (ямар нэгэн арга хэмжээ авахгүй байх) үйл ажиллагаатай холбоотой ойлголт. Жишээ нь: нийтийн хэв журам сахиулж байгаа цагдаагийн алба хаагч нь тухайн болж байгаа үйл явдлыг зүгээр л хараад, ямар нэгэн захиргааны арга хэмжээ авахгүй зогсох.

Эрх зүйн хэм хэмжээг "баримтлах" гэсэн ойлголт нь хууль тогтоомжийг "биелүүлэх", "ашиглах", "хэрэглэх"-тэй харилцан хамааралтай.

"Биелүүлэх" нь захиргааны эрх зүйн хэм хэмжээний нэг хэлбэр болохын хувьд нэг хэсэг бүхэл ажиллагаануудыг багтаасан ойлголт ба олон янзын субъектуудыг хамарч, биелүүлэх шаардлагатай *үүргүүдийг* нь зааж өгч байдаг. Жишээ нь: Олон нийтийн газарт буй иргэн хэд хэдэн дүрэм, журмыг биелүүлэх, эрх зүйн хориглосон хэм хэмжээг сахих, бусад хүний хуулиар олгогдсон эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх ёстой. Тэдгээр үүргүүдээ биелүүлэхгүй байх нь түүнд захиргааны, эрүүгийн эрх зүйн шинжтэй таагүй үр дагаврыг авчрах буюу нийтийн хэв журмыг сахиулж буй цагдаагийн алба хаагчийг хуульд заасан материаллаг болон процессын шинжтэй арга хэмжээ¹ авахад хүргэнэ.

Цагдаагийн албаны тухай хуулиар² цагдаагийн алба хаагчид гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт иргэдийн амар тайван, аюулгүй байдлыг хамгаалах үүрэг хүлээлгэсэн.

"Ашиглах" нь захиргааны эрх зүйн хэм хэмжээний нэг хэлбэр болохын хувьд биелүүлэхээс өөр утга илэрхийлэх буюу үүрэг бус *эрхийн* асуудлыг хөндөнө.

Ф.А.Григорьев³: "ашиглах" нь тухайн субъектэд өөрийн үзэмж, хүслээр түүнд хуулиар олгогдсон эрхийг ашиглаж буй үйлдэл юм" гэсэн. Уг үйлдэл нь иргэнд олгогдоогүй, харин иргэнд өөрийн эрх, эрх чөлөөг хамгаалахтай холбоотой нилээд хэдэн эрх олгогдсон байдаг. Энэхүү хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэх, эс хэрэгжүүлэх нь тухайн иргэний хүсэл, сонирхол, амьдралын, бусад нөхцөл байдлаас шалтгаалж байдаг. Тухайлбал: цагдаагийн алба хаагчийн үйлдлээс болж өөрийн эрхээ зөрчигдсөн гэж үзвэл иргэн хүн дээд шатны байгууллага (удирдлага), прокурорын байгууллага, шүүхэд гомдол

¹Монгол Улсын Эрүүгийн хууль. 20.16 дугаар зүйл. Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах. /Төрийн мэдээлэл. 2016. № 7; Зөрчлийн тухай хууль. 5 дугаар бүлэг. Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэгээрчил. /Төрийн мэдээлэл. 2017. № 24.

² Цагдаагийн албаны тухай хууль. 11, 12 дугаар зүйл. /Төрийн мэдээлэл. 2017. № 8.

³ Григорьев Ф.А. Акты применения права. Саратов. 1995. С. 5.

гаргаж болно. Ийнхүү гомдол гаргаач гэж иргэнийг шахаж шаардаж болохгүй, харин ингэх бүх нөхцөл боломжийг бүрдүүлсэн байх учиртай.

Ийнхүү иргэнээс ялгаатай нь цагдаагийн алба хаагчид хуулиар ногдуулсан үүргээ биелүүлэх эрх нь олгогдсон байдаг. Эрх мэдлийнхээ хүрээнд хүний эрх, эрх чөлөөг хангах, дэг журмыг сахиулахын тулд цагдаагийн алба хаагч эрх зүйн бүх боломжит арга хэрэгслийг ашиглах үүрэгтэй, ө.х. хууль идэвхтэй хэрэглэгч байх ёстой.

Хууль хэрэглэх нь хэд хэдэн онцлогтой байдаг талаар эрдэмтэн судлаачдын бүтээлд дурьдагдсаныг судлан авч үзвэл: В.К. Бабаев: “Хууль хэрэглэх нь өөртөө нэгэн зэрэг янз бүрийн зан үйлдлийн актуудыг хослуулсан эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх цогц, засаглалын үйл ажиллагаа” гэсэн бол В.В. Лазарев: “Хууль хэрэглэх нь эрх бүхий байгууллага, этгээдийн зүгээс өөрт хандаж буй этгээдийн эрх, үүргийг нь хангах, тэрхүү процесс ажиллагаанд хяналт тавих баталгааг олгох зорилго бүхий засаглалын зохион байгуулалттай үйл ажиллагаа”² гэж тус тус тодорхойлжээ.

Уламжлалт ёсоор “хууль хэрэглэх” гэсэн ойлголтод түүний “засагласан” шинжийг зааж өгдөг, учир нь хууль хэрэглэгч нь төрийн төлөөлөгч. Эндээс хуулийн хэрэгжилтийг хангуулах “хууль хэрэглэх” хэлбэрийн ялгаа харагдана. Хууль хэрэглэх нь бүх тохиолдолд төрийн нэрийн өмнөөс хэрэгждэг, эрх зүй, зохион байгуулалтын шинжтэй цогц арга хэрэгслээр хангагдсан байдаг (хүний эдлэх эрх, эрх чөлөөг тайлбарласан эрх зүйн баримт бичиг гаргах, дэг журам тогтоох, ая тухтай нөхцөл байдлыг бий болгох), эцсийн дүндээ хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэгдэнэ.

Цагдаагийн байгууллага нь үйл ажиллагаагаа удирдах, хянах, алба хаагчийн үүргээ гүйцэтгэх явцад урьдаас урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдал үүссэн үед тухайн нөхцөл байдлыг хяналтдаа авах, шийдвэр гаргах зааварчлагаар хангахын тулд үйл ажиллагааны журмыг батлан гаргадаг. Түүнчилэн цагдаагийн байгууллагын захиргааны (дотоод) үйл ажиллагааны нэг хэлбэр болох “үйл ажиллагааг чиглүүлэх” гэдэг нь цагдаагийн байгууллага, алба хаагчаас үүргээ биелүүлэхэд шууд чиглэсэн олон нийтэд үйлчлэх үйл ажиллагааг *удирдлагаар хангах* тухай ойлголт юм. Ингэхдээ удирдлагын зүгээс алба хаагч бүр тодорхой нөхцөл байдалд зайлшгүй хийж гүйцэтгэх болон хийж болохгүй үйлдэл, тохиромжтой шийдвэр гаргах чадвартай болгох асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай, нөгөө талаар цагдаагийн алба хаагч бүр олон улсын хүний эрхийн талаарх баримт бичиг, стандартуудыг мэдэх, хэрэглэх үүрэгтэй юм.

Теория государства и права /под ред. В.К. Бабаева. М., 1999. С. 449.

² Общая теория права и государства /под ред. В.В. Лазарева. М., 1996. С. 211.

Хүний эрхийн зөрчлийг гаргуулахгүй байх, алба хаагчдын хүний эрхийн сэтгэлгээг хөгжүүлэх, хандлагыг өөрчилөх, албаны нэр хүндийг дээшлүүлэхийн тулд цагдаагийн алба хаагч анх ажилд орохоос эхлэн давтамжтайгаар хүний эрхийн сургалтад хамруулах, холбогдох зөвлөмжүүдийг боловсруулан мөрдүүлэх нь зүйтэй байна.

Цагдаагийн байгууллагын хүний эрх, эрх чөлөөг хангах ажил олон арга, хэлбэр (хууль хэрэглэх, зохион байгуулалтын, хүмүүжүүлэх, хууль сахиулах)-ээр хэрэгждэг, тэр дундаас иргэдийн санал санаачлага, өргөдөл, гомдолд түргэн шуурхай хариу үйлчилгээ үзүүлж, тэдэнд мэргэжлийн, материаллаг, бие сэтгэлийн боломжит бүхий л дэмжлэг үзүүлэх нь хүнд суртал, хээл хахууль, албан үүргээ урвуугаар ашиглах, хүний эрх зөрчигдөхөөс хамгаалах, дараа дараагийн гэмт явдлаас урьдчилан сэргийлэх хамгийн энгийн атлаа үр дүнтэй арга юм гэдгийг дэлхий нийт аль хэдийн нотолсон, хүний эрхийг хангах мэргэжлийн үйл ажиллагааг боловсронгуй, үр дүнтэй болгоход цагдаагийн удирдах алба хаагчийн санаачлага томоохон үүрэг гүйцэтгэх юм. ¹

'Community Policing (Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа), problem-oriented policing (асуудалд суурилсан цагдаа), Intelligence -led policing (мэдээлэлд суурилсан хууль сахиулах бодлого) зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үзэл баримтлал, сургааль манай улсад аль хэдийн нэвтэрч, эрх зүйн орчин бүрэлдсэн хэдий ч яг онолын үзэл баримтлал дээр тулгуурлан, олон улсад нэвтэрсэн арга хэлбэр, арга зүйгээр туршин ашигласан, судалгаа шинжилгээ хийж үр нөлөөг судлан дүгнэсэн нь хараахан байхгүй, цагдаагийн алба хаагчид хэрхэн харах, хүлээн авч, хэрэгжүүлэхээс үр нөлөө нь ихээхэн хамаарна. /Харах. Ю.Бадамханд. Цагдаагийн мэргэжлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох хүчин зүйл нь олон нийтэд түшиглэсэн стратеги болох нь. /Тогтвортой хөгжилд-нийгэм, эдийн засаг. ОЭЭХолбоо. Эрдэмтэн эмэгтэйчүүдийн бага хурлын эмхэтгэл. УБ. 2017.